

ХЯТАД ДАХЬ МОНГОЛ ХЭЛНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**М. Зэнээ**

80-аад оны эхнээс Хятад дахь монголчуудын дотор монгол хэл бичгээ сэргээн хөгжүүлэх, хойч үедээ зааж сургах, монгол хэлийг хятад хэлний нэг адил хэмжээнд үзэх хэрэгтэй гэсэн яриа их гарч, ялангуяа Өвөр Монголын өөртөө засах орны (ӨМӨЗО) хэвлэлд энэ сэдвээр монголчууд нэлээд бичих болсон нь анхаарал татаж байна. Монгол хэлийг сэргээн хөгжүүлэх тухай асуудал сүүлийн үед ийнхүү хурц тавигдах болж байгаа нь учиртай юм. Хятад дахь Монгол угсаатан ард түмэн 60-аад оноос 80-аад оны эх хүртэл их хан үндэстний дээрэнгүй бодлогын золиосонд хүчтэй өртсөний улмаас уламжлалт заншлаараа харилцан мэндлэх, төрөлх хэлээрээ хоорондоо санал бодлоо солилцох эрх чөлөөгүй болтлоо хавчигдаж байв. Энэ үед монгол хүн амын нэлээд хэсэг нь монгол хэл бичгээ хэрэглэх эрх чөлөөгүй байсны улмаас төрөлх хэлээ мартахад хүрсэн байна. Ялангуяа залуу үеийнхэн монголоор ярих нь эрс бага болж, монголоор уншиж, бичиж ч чадахгүй болсон юм.

Ийм болно гэдгийг Өвөр Монголын сэхээтнүүд урьдаас ойлгож ӨМӨЗО-ы хэвлэлд бүр 50-иад оны сүүлээр «Хөөрхий дээ!, ӨМӨЗО-ы эзэн нь болсон монгол үндэстний өдий төдий монгол хүүхэд нь нийгэм дээр олбол зохих халамжийг олж чадахгүй байсаар хятадад хайлагдаж (уусч-М.3.) байхыг санахад үнэхээр хөөрхийлөлтэй бөгөөд харамсалтай биш үү»¹ гэж анхааруулан бичиж байсан билээ. 1957 онд явагдсан «баруунтныг эсэргүүцэх хөдөлгөөн», 1966 онд эхэлсэн «соёлын хувьсгал» зэрэг улс төрийн адал балмад кампанит ажлын үед монгол угсаатан ард түмнийг элдэв аргаар хавчин гадуурхаж байсны дотор монгол хэлээ хэрэглэх эрх чөлөөг хассан явдал туйлын жигшүүрт доромжлол болсон юм. Энэ үед Бээжингийн маоист эрх баригчид хятад биш бүх үндэстэнд албан хүчээр хятад хэлийг тулган хүлээлгэхийг оролджээ.

Хэлний асуудалд ингэж хандах явдлаас урьдчилан сэргийлж В. И. Ленин тодорхой анхааруулан бичихдээ «заавал дагах төрийн хэл байх ёстой» хэмээн үзэх нь «албадан тулгах, хүчээр тулгах явдалтай» зайлшгүй холбогдоно. «Ямар нэг хүнийг ташуур далайн сургах»² явдлаар бүх нийтийн гэж үзэх хүчирхэг хэл дутдаггүй юм гэж дурьдаад «диваажингийн оронд бороохойгоор хөөж оруулах» хэрэг-

¹ «Өвөр Монголын өдрийн сонин» 1957.VI.13.

² Ленин. Зохиолууд. 20-р боть. УБ., 1966, 62-р тал.

гүйн адил аливаа хэл сургахад «албадан тулгах явдал хэрэггүй»³ гэж заажээ. В. И. Лениний урьдаас анхааруулж байсан энэ мэргэн заалтыг хятадын удирдагчид практик дээр шууд зөрчсөнөөс болж хятад дахь үндэсний асуудал олон жилийн турш гүн хямрал, хүнд байдалд орсон юм. Олон үндэстний асуудалд марксист байр сууринаас хандаж чадаагүй явдал хятад улсын хөгжилд ноцтой хохирол учруулсан байна. В. И. Ленин «...аль нэг хэлний ямар нэг онцгой эрхийг хадгалснаар өөрийнхөө хөгжлийг саатуулах»⁴ явдалд хүрдэг гэдгийг зааж байсан нь хятадын бодит жишээгээр батлагдаж байгааг ажиглаж болно. Ийнхүү БНХАУ-д оршин амьдардаг монгол угсаатан хүмүүсийн төрөлх хэлний асуудал олон жилийн турш ээдрээтэй хэвээр байна.

Сүүлийн үед, тухайлбал 1980 оноос хойш хятадын удирдагчид БНХАУ-д байдаг хятад биш ард түмний талаар Мао Зэдуны үед явуулж байсан илэрхий алдаатай төрийн бодлогоос зарим талаар ухарч байгаа билээ. Үүнтэй уялдан монгол хэлийг илэрхий хавчих явдал зөөлөрч, харин хөгжүүлэх тухай багагүй ярих болов. Хятад дахь Монгол угсаатан ард түмэн төрөлх хэлээ сэргээн хөгжүүлэхийг ямагт бодолхийлэн байдгийг овжиноор ашиглан «хятадын монгол хэл бичгийн эрдэм шинжилгээний нийгэмлэг» гэдгийг Өвөр Монголд байгуулж, түүний анхдугаар их хурлыг 1980 онд хуралдууллаа.

Хуралд оролцсон ихэнх монгол сэхээтнүүд «...монгол хэлбичгийг түргэн аврахгүй бол цаашид хайлах түгшүүртэй байна гэж тодорхой заахын хамт хэрхэн аврах тухай арга хэмжээнүүдийг боловсруулав»⁵ гэж Өвөр Монголын хэвлэлд тэмдэглэжээ. 1980 онд ӨМӨЗО-д монгол хэлбичгийг хөгжүүлэх, залуу үеийг төрөлх хэлбичигт нь сургах тухай өргөн шүүмжлэл өрнөсний дараа монгол хэл сурах суурь аялгууг цахар аялгуу болгон тогтоосон шийдвэр гаргажээ. ӨМӨЗО-ы засаг захиргаанаас гаргасан энэ шийдвэрийг орон нутгийн засаг захиргаа, нийт монгол хүн ам тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй гэж тэмдэглэсэн байна.

Дэлхийн улс орны хэлний хөгжлийн түүхэнд ямарваа улс өөрийн орны утга зохиолын хэлийг орон нутгийн олон аялгууны хамгийн өргөн дэлгэрсэн амьд хэлэн дээр тулгуурлан хөгжүүлж иржээ. Монгол үндэстний хэлний хөгжлийн түүхээс авч үзэхэд утга зохиолын хэлийг хөгжүүлэх хамгийн их дэлгэрсэн амьд аялгууг буюу суурь аялгуунд Төв аялгууны бүлэгт багтах халх, цахар, ордосын аялгуунууд⁶ зүй ёсоор орсоор иржээ. БНМАУ-ын хувьд утга зохиолын амьд хэл нь халх аялгуу болсон бөгөөд ӨМӨЗО-ы хувьд халх аялгуутай хамгийн ойр нэг бүлэгт багтах цахар аялгууг суурь болгохоор шийдсэн нь монгол хэл бичгийн хөгжлийн асуудалд хятад дахь монголчууд бас их анхаарч байгаагийн гэрч юм.

Сүүлийн 20 гаруй жилд монгол хэлний талаар огтхон ч анхаарал хандуулж байгаагүй хятадын удирдагчид монгол хэлээ сэргээн хөгжүүлэх гэсэн өвөр монголчуудын хүсэл зоригийг гэнэт хөхүүлэн дэмжиж, өвөр монголчуудын санаа сэтгэлд нийцэхүйц зарим арга хэмжээ авч байгаа нь анхаарал татаж байна. Байдал ийм байгаа үед Өвөр Монголын сэхээтнүүд, хэл шинжлэлийн ажилтнууд хятад дахь монгол хэлбичгийн цаашдын хувь заяаны асуудалд онцгой анхаарлаа хан-

³ Мөн тэнд.

⁴ Ленин. Зохиолууд, 20-р боть, УБ., 1966, 5-р тал.

⁵ «Монгол хэл утга зохиол» сэтгүүл. Хөх хот. 1981.VI.20

⁶ «Орчин цагийн монгол хэлзүй», УБ., 1966, 5-р тал.

дуулж олон тооны өгүүлэл бичиж хэвлүүлэх боллоо. Эдгээр өгүүллийн заримаас иш татаж, сүүлийн үед Өвөр Монголд хэлний асуудал ямар байдалтай байгаа тухай дурьдая.

50-иад оноос хойш хятад дахь Монгол угсаатан хүмүүсийн сэтгэл санааг түгшүүлсэн олон асуудал гарч байсны нэгд монгол хэлбичгийн асуудал зүй ёсоор орно. Энэ бүхний учир шалтгааныг бид үндэстний асуудалд марксист байр сууринаас хандаж чадаагүй хятадын маоист эрх баригчдын явуулсан бодлоготой шууд холбон үзэх ёстой. Маогийнхан хятад биш ард түмний хэл соёлд их хан үндэстний дээрэнгүй бодлогын байр сууринаас хандаж, В. И. Лениний тодорхойлсончилон хятад биш «хүн ардын ярьдаг хэлнийг «нохойн хэл» гэж үзэж, бүрмөсөн хориглохоос ч буцахгүй»⁷ тийм байдалд орсон нь хятад ба хятад биш үндэстний хоорондын зөрчлийг туйлаас хурцатгасан ажээ. Зөрчил тэмцэл нэг үе намжиж, нөгөө үед дахин хурцдан гарч ирдэг байв. Өнөөгийн үе бол мөн нэг ээлжит намжилтийн үе бөгөөд урьд өмнөх хурцадсан үеэс ялгаатай нь залхаан цээрлүүлэлт, шахалт хавчилт, хүчтэй дарангуйлалд илт өртөөгүй байгаа явдал юм.

Өвөр Монголд хэвлэгдэж байгаа «Монгол хэлбичиг» сэтгүүлийн 1981 оны № 3-т Хянган аймгийн хэдэн хошуугаар явсан нэг уншигчийн захидал нийтлэгджээ. Уг захидалд хятадад «монгол хэлбичгийг хөгжүүлэх гол зангилаа нь нам, төрөөс үндэстний бодлогод хандах хандлагад оршино. Цөөн тооны монголчууд хятад дахь монгол хэлийг хөгжүүлнэ гэж хичнээн их чармайсан ч уг асуудал шийдэгдэхгүй» гэж Хятадын удирдагчдаас үндэстний асуудалд хандаж ирсэн, хандсаар байгаа бодлогод бүх учир байгаа юм гэдгийг хөндөн гаргаж, түүнд уншигчдын анхаарлыг хандуулжээ.

БНХАУ-д оршин амьдардаг монгол угсаатан хүмүүсийн дунд явуулсан зарим судалгаанаас үзвэл ӨМӨЗО-ы 2 сая 20 мянган монголчуудаас монгол хэлээр ярьдаг нь 1 сая орчим, монгол, хятад хэлээр хольж ярьдаг нь хагас сая илүү, монгол хэлээ мартсан нь 100 мянга гаруй⁸ болоод байгаа ажээ. Үндэсний хэлээ мартаж хятад хэлтэн болох юм уу, эсвэл «холимог хэлтэн» болох явдал нэлээд байгаа нь дээрх жишээнээс ажиглагдаж байна. Гэхдээ ӨМӨЗО-ы монгол хүн амын дунд төрөлх хэлээ мартаж, хятад болох нь бусад хязгаарын монголоос харьцангуй бага бололтой байна. ӨМӨЗО-оос гадна өөр муж, хотуудад байгаа монголчууд монгол хэлийг хэрэглэх нөхцөл, бололцоо тун бага, хүрээлэн байгаа орчин ахуй нь нэлдээ хятад хүмүүс байгаа учир тэнд нэлээд хэцүү тал байдаг ажээ.

Гэхдээ монгол хэлээ хайрлах, хойч үедээ өвлөн үлдээх гэсэн оролдлого хятад дахь монголчуудын дотор тун их байдаг байна. Өвөр Монголчууд монгол хэл устаж үгүй болбол монгол угсаатны онцлог гэж ярих юм мөдхөн байхгүй болно гэж үздэг юм. Иймээс тэд төрөлх хэлээ туйлаас хайрлаж, түүнийг үл тоомсорлох буюу уусгах гэж оролдохын эсрэг эрс тэмцэж ирсэн түүхтэй билээ.

Хэлний асуудал тун нарийн бөгөөд эмзэг асуудал болохыг марксистууд нэг биш удаа тэмдэглэж онцгой анхаарал хандуулж ирснийг байнга санаж байх нь чухал билээ. В. И. Ленин «Үндэстэн эрх тэгш биш байх нь ямар нэг үндэстний хүмүүс төрөлх хэлээ хэрэглэх эрхээ хасагдснаар илэрч байдаг»⁹ гэж

⁷ Ленин. Зохиолууд 20-р боть. УБ., 1966, 62-р тал.

⁸ «Монгол хэлбичиг» сэтгүүл. Хөх хот. 1980. № 4, 12-р тал.

⁹ В. И. Ленин. Гурван боть зохиолын I боть. У; 1974, 308-р тал.

онцлон тэмдэглэж байв. Хятадад «үндэстнүүдийн хооронд үнэндээ эрх тэгш бус байдал байсаар байна»¹⁰ гэж Өвөр Монголын хэвлэлд тэмдэглэж байна. Хятад хэлээр монгол хэлийг орлуулан солих оролдлого «соёлын хувьсгал»-ын үед хэт гаарсан юм. Энэ бол гэнэт гарч ирсэн зүйл биш, харин урт удаан хугацаанд боловсрогдсон маогийнхны төрийн бодлого байв. Мао Зэдун үхэж, «дөрвийн бүлэг» дарагдсанаар хятадын үндэстний бодлогод өөрчлөлт орж байгаа мэтээр гадаадад их шуугиж байгаа боловч «их хан үндэстний дээрэнгүй үзэл», «үндэстний эрх тэгш биш» байдал¹¹ байсаар байгаа тухай, адал балмад кампанит ажил дахин давтагдаж болзошгүй тухай хятадын хэвлэлд ч цухалзах болов.

Сүүлийн үед Өвөр Монголд төрөлх монгол хэлээ хөгжүүлэх талаар нэлээд ярьж залуу үеийг сургах ажлыг эрчимжүүлэх, түүнийг ӨМӨЗО-ы албан ёсны нэгдүгээр хэл болгох шаардлага тавьж байна. Мөн удирдах албан тушаалд хүн дэвшүүлэхдээ монгол хэл мэддэг хүн л дэвшүүлэх хэрэгтэй гэдэг шаардлага тавьж байна. Монгол дарга нар монголоор ярьж, монголоор илтгэл тавьж чаддаг байхыг бас хатуу шаардаж байна. В. И. Ленин «...үндэстний бүгд найрамдах улсуудад үндэстнийх нь хэлбичгийг хэрэгжүүлэх талаар нэн хатуу дүрэм тогтоож...»¹² өгөх хэрэгтэй гэж шаардаж байжээ. Хятадад хятад биш үндэстний хэлээр сургуулиуд хичээллэхийг хатуу хориглож байсан үе бий билээ. Энэ байдал одоо төдий л өөрчлөгдөөгүй байна. ӨМӨЗО-ы бага сургуулиас эхлээд их дээд сургууль хүртэл монгол хэлээр сургалт хүмүүжлийн ажлыг явуулдаг газар үнэндээ алга байна. Өвөр Монголын хаана нь ч очсон хятад хэл албан ёсны хэлэнд тооцогдсоор байна. «Хааяа нэг монгол сурагчидтай монгол сургууль байх боловч захирал нь хятадаар ярьдаг. Сургуулийн аж ахуйн нягтлан бодогч, тогооч, нам эвлэлийн ажилтнуудаас аваад жирийн үйлчлэгч хүртэл хятад монгол хэлийг хольж хутгаж ярьдаг байв»¹³. Энэ нь сурагчдын хэлний боловсролд ноцтой нөлөөлж байна. Хэвлэлийн мэдээгээр Өвөр Монголд 30,500 орчим монгол багш байдаг гэж тэмдэглэж байгаа боловч тэдний дотроос монгол хэл мэддэг нь тун цөөн ажээ. «Сургуулиудаа нутаг нутгийнхаа хэл дээр явуулах бололцоог хүн амд олгон, үндэстнүүдийн нэгэнд ямар нэг илүү эрх дарх олгох ба үндэстний цөөнхүүдийн эрхийг ямар нэг талаар зөрчдөг явдлыг хүчингүй болгон зарлах»¹⁴ нь улс төрийн гол зүйл болохыг В. И. Ленин цохон тэмдэглэж байжээ.

Өвөр Монголын сэхээтнүүдээс хэлний талаар санаа зовж байгаа бас нэг асуудал бол «холимог хэлтэн» олширч байгаа явдал гэж үзэж байна. Өвөр Монголын хэвлэлд удирдах хариуцлагатай ажил хийдэг нэг монгол дарга олон түмний цуглаан дээр «Гуан да ши юань тарианд лодун-нууд лоли бас бугао тул фуню-гээ фадун-нагуулж байгаад шинчжань-аа сайн гао-х хэрэгтэй»¹⁵ гэж хэлжээ. Энэ нь монголчилбол «Өргөн их коммуны гишүүд тариан талбайд ажиллахад ажиллах хүч хүрэлцэхгүй байгаа тул эмэгтэйчүүдээ дайчилж байгаад үйлдвэрлэлээ сайн хийх хэрэгтэй» гэсэн үг юм байна. Захидал бичигч

¹⁰ «Монгол хэл бичиг» сэтгүүл. Хөх хот. 1980. № 4. 12-р тал.

¹¹ Мөн талд.

¹² В.И. Ленин. Түүвар зохиол гурван ботийн III боть. УБ., 1976

¹³ «Монгол хэлбичиг» сэтгүүл. 1981. №3. 108-р тал.

¹⁴ В.И. Ленин. Зохиолууд. 20-р боть. УБ, 1966, 62, 63-р тал

¹⁵ «Монгол хэл бичиг» сэтгүүл. 1981. № 3. 108-р тал.

Хорчин баруун гарын дунд хошуунд очиж дэлгүүрт ороод «Боорцог нэг жин худалдан авъя» гэхэд дунд зэргийн нуруутай худалдагч эмэгтэй пүс хийтэл инээд алдаж «манай хэцзоши-д (дэлгүүрт) баоцзы (бууз) байхгүй» гэж хэлээд хажуу дахь эмэгтэйдээ «үг нь ойлгогдохгүй монгол байна. Арын хүн...(БНМАУ-аас ирсэн хүн—М.З.)» гэв. Ингэж хэлэх нь яахав. Эндхийн сургуулийн 40, 50 сурагчид хэнээс сонссоныг бүү мэд «Үг нь ойлгогдохгүй Арын хүн» гэж намайг хүрээлэн зогсож, гайхам харах нь яг амьтны хүрээлэнд нэг хачин амьтан үзэж байгаа мэт болсон» гэжээ. Энэ жишээнээс үзэхэд хятад дахь монголчууд төрөлх монгол хэлээ мартаж, хятадтай хольж хутган ярьж «холимог хэлтэн» болж байгаа нь харагдаж байна. Үүнийг сүүлийн үед өвөр монголын сэхээтнүүд нэлээд шүүмжилж байна. «Үг хэл, үсэг бичгийг хязгаарласнаас болоод хятадчилагдсан монгол хэлтэй газар монгол, хятад радио нэвтрүүлгийн алийг нь ч монгол хүмүүс ойлгохгүй болжээ»¹⁶ гэж хэвлэлд бичжээ. «Ийм нөхцөлд бид сард үхэр, хонины нэг хоёр жин (0,5 кг) мах, хуурай тариа идэж, хэдэн монгол үсэгтэй үүдний хаяг өлгөөд, хэдэн монгол дуу сонсчихвол нам, төрийн үндэстний бодлого тууштай хэрэгжиж байна гэж хэлж яаж болох вэ» гэж захидал бичигч өгүүлээд цаашид монгол хэл, үсэг бичгийг хөгжүүлэх шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаарджээ.

«Монгол хэл бичиг» сэтгүүлийн 1981 оны № 2-т Тогоо гэдэг хүний бичсэн «Хорчины холимог хэллэгийг арилгаж хэлээ цэвэр чийргээр хөгжүүлэе» гэдэг өгүүлэл нийтлэгдсэн байна.

«...Үндэстний хэлийг хятад хэлэнд ойртуулах буюу шилжүүлэх» гэдэг зорилт тавигдаж «холимог хэллэгийг» нэг ёсны дэвшилт үзэгдэлд тооцох болсноос «холимог хэллэг» харчин, түмэд, хорчин нутгаар их дэлгэрч байсан бол сүүлийн үед баарин, үзэмчин зэрэг бүхэлдээ малчид суурьшдаг хошуунд ч дэлгэрдэг боллоо»⁷ гэж Өвөр Монголын хэвлэлд бас бичжээ. Энэ үзэгдлийг хятад дахь монголчуудын үндэстний хэлэнд бий болсон түүхэн гутамшиг гэж эрс шүүмжилж байна. 1981 оны мэдээгээр Зуу-Уд аймгийн төв суурин газрын монгол хүүхдүүдийн олонхи нь эх хэлээрээ ярьж чадахгүй байжээ.

«Монгол хүнийг хот оруулж болохгүй. Хот орвол хятад болчихно гэж зарим хүмүүсийн ярьдагийг тэр чигээрээ буруу гэж үзэх арга алга»¹⁸ гэж Өвөр Монголын хэвлэлд тэмдэглэсэн нь хэлний уусгалтаас өвөр монголчууд болгоомжилдогийн гэрч юм.

Сургуулийн багш ажилчид, сурагчдын дотор хятадууд цөөхөн байсаар атал сургалт хүмүүжлийн ажлыг заавал хятад хэлээр явуулах явдал газар авч байна. Зарим хүмүүс «...хятад хэлээр ярихыг их эрдэм чадвартайд тооцож» байгаа нь «бурам долоосон хүүхэд эхийн сүүг гашуун гээд нулимав» гэдэгтэй тун адил байна»¹⁹ гэж Өвөр Монголын хэвлэлд тэмдэглэж байна.

Хэвлэлд тэмдэглэснээс үзвэл хэрэв энэ байдлаар цаашид үргэлжилвэл «хойч үе маань чухам ямар хэл, ямар бичиг, ямар зан заншилтай ямар хүмүүс болж хувирах вэ»²⁰ гэжээ. Өгүүлэл зохиогч «Бид өдөр бүр төрийн үндэстний бодлого биелж, сурган хүмүүжүүлэх ажил хөгжиж, өөртөө засах эрх хэрэгжиж байгаа мэтээр өндөр дуу-

¹⁶ Монгол хэл бичиг сэтгүүл. 1981. № 3, 108-р тал.

¹⁷ «Монгол хэл бичиг» сэтгүүл, 1981. № 4. 15-р тал.

¹⁸ «Монгол хэл бичиг» сэтгүүл, 1981. № 4. 15-р тал.

¹⁹ Мөн тэнд. 16-р тал.

²⁰ «Монгол хэл бичиг» сэтгүүл. 1981. № 4.

гаар ярьдаг. Гэтэл залуу үе маань энэ хэмжээгээр төрөлх хэлээ мартаж байна» гэж хурцаар шүүмжлээд «хэргэм зэрэг, эрх тушаал хөөцөлдөж, эд ашгийн хойноос шунан тэмцэлдэж явсан манж ноёд зөвхөн өөрийн биеийн жаргалыг эрхэмлэж, хойч үеэ хайхрахгүй байсаар үндэс угсаагаа өөрийн биетэйгээ хамт авсанд хийсэн биш үү. Энэ түүхт сургамж өнөөгийн монгол дарга нарын анхаарлыг татахгүй байна уу? Татсан ч ойшоохгүй байна уу?»²¹ гэж маш ноцтой анхааруулсан нь сонирхол татаж байна. Өгүүллийг бичигч урьд өмнө ийм асуудал тавьж хэлмэгдэж байсан боловч бодол санаанаасаа ухарсангүй. Түүний бичсэн энэ мэт хурц үг, өгүүлбэртэй өгүүллийг хориглолгүй хэвлэсэн нь ч бас сонирхолтой байна. Өвөр Монголын ард түмний энэ мэт хатуу шаардлага монгол хэлийг хөгжүүлэх тухай цаашдын бодлогод анхаарвал зохих зүйл болж байгаа бололтой. Иймээс ч монгол хэлийг хөгжүүлэх бодлого баримтлах болсон байж болох юм.

Хятад дахь монгол хүн ам сүүлийн үед хятад биш үндэстний талаар хятадын нам, төрөөс явуулж байгаа бодлогыг нухацтай ажиглан харж, одоогийн бодлого «хойч үеийнхэнд холбогдолгүй, зөвхөн бид мэтийн авсны хаалга өөд дөхөж яваа хүмүүст зориулагдаж...байгаа бол тийм хүч, хөрөнгө зарах хэрэггүй»²² гэсэн шаардлагыг ч хүртэл тавьж байна.

Өвөр Монголын эрдэм шинжилгээний ажилтнууд өсвөр үе төрөлх хэлээ хэрхэн сурч байгаа байдлын талаар зарим судалгаа явуулж үзжээ. 1980 онд хийсэн судалгаагаар «Хөх хотын монгол сургуулийн 1-р ангид элсэн орсон 163 монгол хүүхдийн 90 гаруй хувь нь монгол хэл мэдэхгүй. Үлдэх 10 орчим хувь нь хүний хэлэхийг ойлговч ярьж чадахгүй байсан ажээ. Ер нь 1976—80 оны хооронд сургуульд орсон монгол хүүхэд ийм л харьцаатай байсан»²³ байна.

Төрөлх хэлээ хэрхэн эзэмшиж байгаа байдалд судалгаа хийсэн хүмүүс хятадад «монгол хэл бичиг хэрэглэж байгаа байдал нь Египетийн пирамид шиг байна» гэсэн дүгнэлт хийжээ. «Учир нь орон нутгийн засаг захиргааны анхан шатны байгууллага болох бригадад монгол хэлийг хамгийн өргөн хэрэглэж, нэгдэлд монгол хэлийг голлон, Хятад хэлийг хавсруулж, хошуу сянъд голчлон хятад хэлээр ярьж, дээшлэх тусам монгол хэл хэрэглэх нь улам багасаж байна»²⁴ гэжээ. Өвөр Монголын хэвлэлд монгол хэлний талаар бичигдсэн сэдвүүдийг уншиж үзэхэд монгол хэлээ сэргээн хөгжүүлж, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх гэсэн санаа тун их байгаа нь ажиглагдаж байна. Энэ байдлыг гярхай ажиглаж, өвөр монголчуудын санаа сэтгэлийг засах зорилгоор хятадын удирдагчид сүүлийн үед хятад хүмүүс монгол хэл сурах хэрэгтэй»²⁵ гэсэн уриа дэвшүүлдэг боллоо. Энэ бол монгол хэлийг хавчин шахаж, сурах явдлыг хориглож, доорд үзэж байсан бодлогоосоо илүү ноцтой бодлого юм. Хятадууд хятад биш үндэстний хэл сурснаар тэдгээр үндэстний дотор хуучнаасаа гүн нэвтрэн орж, Бээжингийн төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд улам амжилт олох нөхцөлийг хангана гэж үзэж байгаа бололтой.

Сүүлийн жилүүдэд «хятад хүмүүс монгол хэл сурах» хөдөлгөөн өрнүүлж байгаагийн нэг тодорхой жишээ бол 1968 онд Бээжингээс

²¹ Мөн тэнд.

²² «Монгол хэл бичиг» сэтгүүл. 1981. № 4. 76-р тал.

²³ Мөн тэнд. № 3, 9-р тал.

²⁴ «Монгол хэл бичиг» сэтгүүл. 1981. № 3. 9-р тал.

²⁵ «Чайна дейли» сонин, 1983.IX.23. (англиар)

Өвөр Монголд ирсэн Чжоу Бинцзянь хүүхэн болж байна. Энэ хүүхний тухай хятадын хэвлэлд ихээхэн сурталчилж байна. Ерөнхий сайд агсан Чжоу Эньлайн «ач охин» гэгдэх Чжоу Бинцзянь 1968 онд 15 настайдаа Өвөр Монголын Шилийн гол аймагт малчинаар ирсэн ажээ. Удалгүй Өвөр Монголын их сургуульд орж суралцан, монгол хэл утга зохиолын ангийг төгсчээ. Сургууль төгсөөд хэсэг хугацаанд баруун үзэмчин хошуунд байснаа Хөх хотод шилжиж, одоо Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн монголын уран зохиол судлах хүрээлэнгийн тасгийн эрхлэгч болоод байгаа юм. Чжоу Бинцзянь монгол хэлийг сүрхий сайн сурсны зэрэгцээ монгол үндэстний дуучин Лхаасүрэн гэдэг залуутай суусан нь «хятад эмэгтэйчүүд хятад биш үндэстэнд хадамд гарах хэрэгтэй» гэсэн Чжоу Эньлайн уриалгыг биелүүлж байгаагийн бас нэг жишээ болж байна» гэжээ. «Жэньминь жибао» сонинд тэмдэглэснээс үзвэл Чжоу Бинцзянь хүүхэн Чжоу Эньлай, түүний гэргий Дэн Инчао нарын «хил хязгаарт бэхжин суурьшиж, монгол үндэстний хамт хилийн бүтээн байгуулалтанд оролцох хэрэгтэй»²⁶ гэсэн даалгаврыг үлгэр жишээ биелүүлж байгаа хүн ажээ. Ийнхүү монгол хэл нэг үе ямар ч хэрэггүй мэт байсан бол өнөөдөр монгол, хятад үндэстэн бүгдээр сурвал зохих хэл болсон мэтээр сурталчилж байна. Монгол хэлийг хятадууд сурч, хятад хэлийг монголчууд сурах нь олон үндэстнээс бүрэлдэн тогтсон БНХАУ-ын «Үндэстнүүдийн эв найрамдал»-д онц чухал зүйл гэж хятадын хэвлэлд тэмдэглэдэг боллоо. Өвөр Монголд хятадууд уугуул хүн амаас нь 17 дахин их байгаа өнөөгийн нөхцөлд монгол хэл албан ёсны хэл болох бодит боломж үнэндээ бага байна. Монгол хүүхдүүд нь хятад хүмүүсийн тойрон хүрээлсэн нөхцөлд өсч байна.

Монгол хэл сурах, хэрэглэх тухай ярьж бичиж, ном зохиол зохих хэмжээгээр хэвлэж байгаа энэ бүх ажлын цаана монголчуудын түүхийг гуйвуулах, үндсэрхэг үзэл дэвэргэх санаа сэтгэлийг засаж эзэмдэх, улмаар дэлхийн монгол судлалын төвийг Өвөр Монголоор дамжуулан хятадад шилжүүлэн авах гэсэн хэтийн тодорхой зорилго агуулж байна.

СОВРЕМЕННОЕ ПОЛОЖЕНИЕ МОНГОЛЬСКОГО ЯЗЫКА В КИТАЕ

(Р е з ю м е)

В своей статье автор анализирует современное положение монгольского языка в Китае, в особенности во Внутренней Монголии, а также нынешние выступления интеллигенции Внутренней Монголии в печати по данному вопросу. Ссылаясь на конкретные материалы в печати Внутренней Монголии, автор приводит факты о том, что из 2 миллионов 20 тысяч монголов этого автономного района лишь около миллиона людей знает свой родной язык и более полмиллиона смешивает свой разговор с китайским языком, а 100 тысяч человек вообще не умеет говорить по-монгольски.

²⁶ Мөн тэнд.

По данным исследователей в АРВМ, хотя идет в последние годы разговор о восстановлении и развитии монгольского языка в АРВМ, к сожалению, в районе нет ни единого учебного заведения, где дети могли бы учиться на родном монгольском языке, начиная с начальных школ и кончая высшими учебными заведениями.

Внимание автора привлекает требование в печати интеллигенции Внутренней Монголии китайскому правительству о признании монгольского языка как официального по всему району, о необходимости назначения на высокие посты людей, которые хорошо знают монгольский язык, во всех учебных заведениях вести предметы на этом языке и др. Представители интеллигенции Внутренней Монголии критикуют измерение образованности людей в этом районе по степени знания китайского языка. Они также беспокоятся тем, что, если эта тенденция дальше будет долго продолжаться, то монгольский язык в Китае, особенно во Внутренней Монголии, постигнет такую же участь, какую постиг в свое время маньчжурский язык.

В заключении статьи автор обращает внимание на меры по изучению китайцами монгольского языка в Китае и на их цель, т. е. китайское руководство этими мерами стремится к тому, чтобы еще глубже проникнуть в душу внутренних монголов и тем самым перенести центр мирового монголоведения в Китай, в частности во Внутреннюю Монголию.